

ЭРТ ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ
ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТУХАЙ АСУУДАЛД

(XII-XIV зууны үеийн Монгол үндэстний
сурвалж бичиг материалын жишээн дээр)

Дагуул*

* Өвөр Монголын их сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн Сонин мэдээний ухааны салбарын доктор, дэд профессор

Түлхүүр үг: монгол үндэстэн, мэдээ занги, мэдээллийн хэлбэр, мэдээллийн харилцаа, мэдээллийн үр нөлөө

Эрт үеэс аливаа улс үндэстэн өөрсдийн оршин буй байгаль нийгэм, аж амьдрал, соёл заншлын талаар мэдээ занги нэвтрэлцэх арга барилыг эзэмшсээр иржээ. Монгол үндэстэн ч бусад улс үндэстний адил урт удаан хугацааны түүхэн хөгжлийн явцдаа өөрийн мал маллах амьдралын хэв маягт тохирсон мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн хэлбэрийг ашиглан, мэдээлэл харилцаа явуулсаар ирсэн байна.

Нэг. Мэдээллийн хэрэгсэл

Түүхэн сурвалж бичиг материалыг үндэслэвэл, XII-XIV зууны үеийн Монгол үндэстний мэдээлэл нь их төлөв аман мэдээлэл хийгээд бичмэл мэдээлэл гэх хоёр мэдээллийн шат үеийг дамжжээ гэж үзэж болно. Монгол хэл бол монгол үндэстний харилцааны хамгийн гол үндсэн хэрэглүүр юм. Гэвч Монгол хэл нь чухам аль үед хэрхэн

бий болсон тухай олон жилийн турш адил бус саналууд байсаар байна. Өөрөөр хэлбэл, "Тус асуудал бол маш будлиантай байж, тодорхой хэлэхэд түвэгтэй. Гэвч наад зах нь 1206 онд Чингис хаан монгол аймаг овогтныг нэгтгэж Монгол хаант улсыг байгуулах үеэр монгол хэл нэгэнт бүрэлдээд байв. Юань улсын ноёрхож байсан XIII-XIV зууны үед монгол хэл хөгжөөд нэлээд нэгдэлтэй болсон байна". Монголчууд өвөр зуураа мэнд мэдэх, хэл хүргэх, адуу малаа алдаж эрэл сураг тавих зэрэг нь аман мэдээлэлтэй салшгүй холбоотой байв. Иймээс монголчуудын дунд "Эрлийг сургаар, эрдмийг хичээлээр" хэмээх үг хэлээр мэдээ занги уламжлахын үр нөлөө, ач холбогдлыг нотолсон оновчтой зүйр цэцэн үг буй болжээ. Монголын нийгэмд аман мэдээлэл нь нийгмийн эмх дэглэмийг хамгаалах, нийгэмшил зэрэг талаар чухал нөлөө үзүүлсээр иржээ. Жишээлбэл, "Монголын нууц товчоо"-нд Хорчиноос "Бодончир богдын барьж авсан эхнэрээс төрсөн бид бүгдээр, Жамухатай хэвэл нэгтэн,

хэвтэш гагцтан. Жамухаас салж болохгүй шүү, бид. Гэвч, Заарин тэнгэр (сахиус) ирж, миний нүдэнд үзүүлжээ. Нэг хуагч үнээ ирээд, Жамухыг тойрон явж, гэр тэргийг нь мөргөхийн хамт, бас Жамухыг мөргөөд, ерөөсөн эврээ хугалжээ. Ингээд солжир эвэртэй болоод, Жамухын зүг хандаж, эврий минь авчир гэж мөөрөөд зогсохуй, бас шороо сацан сацан мөөрч байна. Бас мохор хуа үхэр их гэрийг сууриар нь дээр өргөж, тэргэнд хөллөөд зүтгэж, Тэмүжиний хойноос их тэргэл замаар мөөрөн мөөрөн ирж, тэнгэр газар зетэлдэж, Тэмүжинийг улсын эзэн болтугай гэж улсыг тээн хүргэж явна гэж мөөрмүй ийнхүү заарин тэнгэр (сахиус) нүдэнд үзүүлж байгаад надад заан өгч байна шүү”² гэжээ. Ингээд тухайн үед бусад олон аймгийн түрүү нар Хорчиний хэлснийг сонсоод өөрийн ард иргэнээ дагуулан Жамухаас салж Чингист ирж түшиглэв. Чингис хаан ч Хорчиний бүх шаардлагыг тэр ёсоор зөвшөөрөөд үнэхээр хожим нь үгэндээ хүрчээ. Үүнд Хорчийн ухуулга, Жамухын байр суурь, итгэл хүндийг доошлуулж, Чингисийн нэр хүндийг нэмэгдүүлэхэд аман мэдээллийн үүрэг нөлөө их байсан нь яриангүй. Тиймээс Чингис хаан бөөгийн шашныг дэлгэрүүлэхэд яриа хэлэлцээг уян хатан ашиглаж, Монгол хаант төрийг цогцлоон байгуулах их үйлсдээ үйлчлүүлж байсан ор мөр тодорхой харагдаж байна.

XII-XIII зуунд Чингис хаан тархай бутархай Монгол овог аймгийг дайлан дагуулж, нэгтгэх явцад дайн байлдаан, шашин шүтлэг, гадаад харилцаа, үйлдвэрлэл зэрэгтээ аман мэдээллийг голлон ашиглаж байжээ гэдгийг бид “Монголын нууц товчоо” зэрэг түүхийн тулгуур бичиг дэх аман мэдээллийн

тэмдэглэлээс харж болно. Жишээлбэл, дайсны довтлолд учрах буюу дайсныг довтлох үедээ Чингис хаан урдаар заавал хуралдай хийж доорх тушаалтнуудынхаа саналыг сонсдог. Үүний дагуу туршуул илгээж, дайсан этгээдийн үнэн байдлыг туршуулж, дайсны улсын байдал, цэргийн хүчин, эд хөрөнгө, хот балгас, зам мөр болон цэргийн удирдагч зэрэг олон талын мэдээ зангийг мэдэж авдаг байжээ. Эдгээр нь тухайн үед аман мэдээлэл нь хамгийн чухал ач холбогдол үзүүлж, өргөн хэмжээнд хөгжиж байсныг харуулж болох юм.

Бичгийн мэдээлэл буй болохоос өмнө аман мэдээлэл нь ерөөс голлох байранд оршиж байсан боловч аль нэгэн хязгаарлагдмал байдлаас болж мэдээллийн явцад чадавх нь ихээр буурдаг. “Лүй овогтын Чүн Чиү бичиг: нарийвчлан уламжлахад түүнээс олсон үгийг нарийвчлахгүй болохгүй, хэд хэдэн удаа уламжлахад цагааныг хар, харыг цагаан болгомуй. Зориуд нохойг хөгшмөл самж мэт, хөгшмөл самжийг эм сармагчин мэт, эм сармагчныг хүн мэт, хүн болон нохой болбоос хол өөр болой” гэж аман мэдээллийн явцуу чанарын тухай оноож хэлсэн зүйл байдаг. Энэ нь аман мэдээллийн хүлээн авагч мэдээллийг хүлээн авахдаа санамсартай буюу санамсаргүйгээр эмхтгэн засварлах, өөрийн ойлгож байгаагаараа дараа нэг хүлээн авагчид уламжлан дамжуулдаг ас андуу ташаа мэдээ нийтэд дэлгэрэх, буруу мэдээллийн үр дүн үүсэх онцлогийг харуулж буй.

Аман мэдээллийн гол чанар нь “нэгээс арав, арваас зууд” уламжлагдан дамжих явцад нөлөөлөх нь дамжиггүй. Тиймээс Монгол хаант төрийн

үед мэдээллийн үнэн бодит шаардлагад нийцүүлэх зорилгын үүднээс аман мэдээллээс гадна пайз тэмдэг, туг далбаа, цан хэнгэрэг мэтийн мэдээллийн хэрэгслийг үйлдэж аман мэдээлэлд нөхвөр болгож байв. "Марко Пологийн өдрийн тэмдэглэл"-д Хубилай хааны байлдаанд гарах үеийн байдал төлөвийг "жагсаалаа нэгэнт жагсаасны хойно, татаар хүний зан суртлаар байлдахын өмнө зүйл зүйлийн бишгүүр хөгжмийг зэргээр үүсгэн үлээж, дагалдаагаар дуу дуулж, цан хийгээд хэнгэрэг дэлдэх цагт хүрч сая эхлэн байлдмуй. Дуу дуулж, цан цохих, хэнгэрэг дэлдэх нь цөс маш сүрхий, сонссон хүн айн цочиж үл бармуй. Энэхүү зарлал дохио нь их хаанаас урдаар зүүн баруун жигүүрийн цэрэг түр зарлан гаргаж, түүний их хэнгэрэг нь дэлдэн эхлэхэд нэгэн догшин сүрхий цусан байлдаан эхэлмүй"³ гэж тэмдэглэж буй. Эдгээр туслах мэдээллийн хэрэгсэл нь зохих хэмжээнд аман мэдээллийн хязгаар чанарыг ялан давж, адил нэгэн цаг дахь хүлээн авагчийн тоог нэмэгдүүлж, мэдээллийн үр бүтээмжийг дээшлүүлэх боломжийг ханган өгч байжээ. Өөрөөр хэлбэл, бишгүүр хөгжим, цан хэнгэрэг, туг далбаа зэрэг нь цэрэг ардын сүр хүчийг нэмж, урагшлан давшихад ахиц өгдөг байжээ.

Монголчууд угаасаа үсэг бичиггүй байв. Сурвалж бичиг материалаас үзвэл, монголчуудын эрт үеийн бичмэл мэдээлэл нь анхандаа зураг дүрс буюу сийлмэл тэмдэг зэргийг ашиглаж мэдээлдэг байжээ. Өмнөд Сүн улсын Зуу Гүн гэдэг хүний бичсэн "Монголын байдлын тэмдэглэл" ба Пин Да Яа, Сиүй Тин хоёр хамтарч зохиосон "Хар Монголын

явдлын товч тэмдэглэл"-д тэмдэглэсэнээс үзэхэд "Монголчууд үсэг бичгийг хэрэглэхээс өмнө: зарлиг буулгах буюу элчин илгээхдээ учир явдлыг жижиг модон дээр тэмдэг сийлж тэмдэглэдэг байлаа. Монгол орондоо хэрэглэх зүйлийг хэлбэл жижиг мод л байлаа. Тэр нь уртаар 3-4 ямх бөгөөд 4 сэжүүрт нь тэмдэг сийлдэг юм. Энэхүү жижиг мод бол эртний модон баримт гэдэгтэй адил буюу"⁴ гэжээ. "Зарим судлаачдын үзлээр манай он тооллын X зууны эхэнд монголчууд нэгэнт үсэг бичигтэй болжээ. Юу ч гэсэн XIII зууны эхэнд монголчууд нэгэнт үсэг бичигтэй болов гэдгийг дэлхий даяараа хүлээн зөвшөөрч байна"⁵.

Үсэг бичгийн буй болсон нь аман мэдээллийн цаг оронд хязгаарлагддаг дутагдлыг орон зайн хэмжээгээр нөхвөрлөдөг. Бичгийн мэдээллийн олонх нь тухайн үеийн Монголын нийгмийн улс төр, аж ахуй, цэргийн явдал, хууль дүрэм, ёслолын байдлыг тусгасан чухал материал байж, тодорхой бичмэл түүхийн шинжтэй. Энэ үед хөшөө чулуу нь ч үсэг бичгийн мэдээллийн хэрэгсэл болсон байна. Монгол үндэстний хамгийн эртний чулуун хөшөөний бичиг бол 1225 оны "Чингисийн чулууны бичиг" болно. Тус чулуун хөшөөний Есүнгэгийн гурван зуун гучин таван алд хол харвасан гайхамшигтай явдлыг тэмдэглэсэн нь одоогийн сонин мэдээнийх шиг цаг, орон, хүн, хэрэг, үр дүн гэх таван үндсэн элементтэй байна. Иймээс утга агуулгаас нь үүнийг монгол үндэстний хамгийн анхны үсэг бичгээр илтгэсэн сонин мэдээ гэж үзэхэд хэтрүүлэл болохгүй. Одоо болтол хадгалагдаж байгаа уйгаржин монгол үсгийн дурсгал бичиг болон 1269 онд Хубилай хааны

зарлигаар Пагва ламын зохиосон дөрвөлжин үсгээр бичсэн хөшөөний бичиг нэлээд олон бий. Эдгээр мэдээлэл нь одоогийн хүнд хэдийвээр өнө удаагийн цуваа цагийн мэдээлэл болж танигдаж байгаа боловч тухайн үедээ зохих хүрээнд хам цагийн мэдээллийн үйлдэл үзүүлж байсан нь лавтай юм.

Хоёр. Мэдээллийн хэлбэр

Монгол үндэстний эрт үеийн мэдээллийн ажиллагаа нь хэлбэр дүрсээр олон янз, агуулга сэдвээр элбэг баялаг байлаа. Үүнийг их төлөв албаны мэдээлэл болон ардын мэдээлэл гэж хоёр давхаргаас задлан ярьж болно.

1. Албаны мэдээлэл. Төр гүрний засгийн хэргийг тэмдэглэх ба мэдээлэх хэрэгцээ шаардлагаас түүхч түшмэл тохиолыг дагаж буй болсон юм. Эрт үеийн түүхч түшмэл, төр засагт үүссэн их бага явдлыг тэмдэглэн зарладаг. Хэдийгээр тухайн үеийн төр гүрний засгийн явдал болон хаан эзний үг яриа, үйл ажиллагааг тэмдэглэх нь хам цагийн мэдээллээр гол зорилгоо болгодоггүй боловч дэлгэрэнгүй утгаас ярьвал, өнөөдрийн түүх нь тухайн үеийн сонин мэдээ, тухайн үеийн сонин мэдээ нь маргаашийн түүх болж хоцордог нь ертөнцийн жам юм. Эрт үеийн түүхч түшмэлийн хэрэг явдлыг үнэн мөнөөр тэмдэглэх зорилго, төв хянамгай байдал, утга гүн үг хэлээр нарийн утга санааг илтгэж байсан нь хожмын түүхэн мэдээлэлд маш чухал нөлөө үзүүлсэн юм.

Төр гүрний засаг зарлиг, цэргийн явдал, гадаад харилцаа зэрэг үйл явдлын хөгжлийг даган, албаны талын мэдээлэл харилцаа өдөр ирэхүйеэ олширсон байна. Энэ нь эн тэрүүнд

албан бичгийн мэдээллээр илэрч байв. Чингис хаан 1206 онд Их Монгол улс байгуулсныхаа дараа төр улсаа засч, ноёрхлоо бэхжүүлэх олон талын засаг дүрмүүдийг явуулсан байна. Үүнд: хараат өрхийг хуваан захирах дүрэм, хишигтэн цэргийн дүрэм, их шүүгч ноёныг томилсон, шашин суртахууны төрийн бодлого, цааз засаг зэргийг тогтоон хэрэгжүүлэв. Тухайн үед албаны талын мэдээллийн арга хэлбэр нь олширч, мэдээ зангийн солилцоо нягт болсон нь тодорхой илэрч байлаа. Мэдээ зангийн тусгай үүрэгтэй тагнуул, туршуулч, элч, холбоочин томилох, эсвэл нааш цааш явах худалдаачин наймаачин, элчин сайд, жуулчид, олзлогсдоор дамжин бусад улс үндэстний байдлыг мэдэж ойлгодог байжээ. Цаашлаад дэлхий ертөнцөд танигдсан мэдээ занги дамжуулах үүрэг бүхий ертөөний зохион байгуулагчид буй болсон юм.

Төрийн хууль зарлиг нь өөр бусдад мэдээлэн дамжуулахыг шаарддаг юм. Аль эрт Чингис хаан Их Монгол улсыг байгуулахаас өмнө монголчуудын дунд нэлээд олон ёс байсан бөгөөд эдгээр ёсонд нь хэв журам, зан суртахуун, үлгэр жишээч зэрэг олон зүйлийн утга агуулга багтаж байжээ. Энэ тухай бид "Монголын нууц товчоо"-н дахь Алунгоо эхийн "Таван мөсөөр хүүхдүүдээ сургасан домог" болон монголчуудын их хуралдайгаар хүнд чухал хэрэг явдлыг таслан шийтгэж байсан зэрэг тэмдэглэлээс мэдэж болох юм. "XII зуун болж, Монголын нийгмийн эл аймгийн толгойлогчид өөрийн ноёрхлоо чангатгахын төлөө хараат арддаа зарлиг-засаг байгуулах болов. Тэдний байгуулсан засаг нь ард иргэдийн эрхбиш

баримтлан сахих хууль цааз болжээ. Энэ нь даруй засгийн эх үүсэл болно»⁶.

Их Монгол улс байгуулагдаж үсэг бичигтэй бичмэл хуулийг нийт олонд зарлан мэдүүлэх боломжтой болов. Үсэг бичгийг өдөр ирэхүйеэ олон хүнд ашиглахыг хэрээр тэр нь нийгэм нийтэд мэдээ занги, мэдлэг уламжлах чухал багаж болсон байна. Хууль цаазын дүрэм тогтоол нь энэхүү хэлбэрээр дамжин тархаагдах нь дамжиггүй. 1206 онд Чингис хаан Монгол хаант улсыг байгуулмагц өөрийн тогтоол цаазаа эл хүрээнд хэрэгжүүлж, хойч үедээ уламжлахын төлөө хууль цааз төрийн ёсыг явуулахын тулд Ши-

хихутагийг томилон бүх улсын хамгийн их шүүгч ноён болгов. Чингис хаан түүний үүргийг нь "Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг нь үхүүлж, яллах ёстойг яллаж бай" гэж тогтоогоод бас "Нийт улсын өмчийг хувааж, заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Надтай зөвлөж, Шихихутагийн шийтгээд цагаан цаасан дээр хөх үсэг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй. Өөрчилсөн ардыг ялтан болгон шийтгэтүгэй"⁷ гэж зарлиг болгов. Ингээд монгол үндэстний түүхэн дэх хамгийн эртний үсэг бичгээр тэмдэглэсэн бичмэл хууль үүнээс эхлэн буй болжээ. Энэхүү тэмдэглэл нь тухайн үед хууль цаазыг улс даяар үсэг бичгийг ашиглан тархаан зарлаж байсныг харуулж болох юм.

Албан бичиг, хууль зарлаас гадна, бас Их Монгол улсын дайны үеийн цэрэг-дайны тухайтай мэдээ буюу яаруу мэдээ мэдээллийн байдлыг ч дурдууштай юм. "Чингис хаан монгол аймгуудыг нэгтгэн захираад овог аймгийн холбоо, дайн байлдааны чимээ, яаруу мэдээг уламжлан дамжуулах шаардлагаар харьяалагдан бүхий орнуудад өртөө байгуулсан байна"⁸.

Өгөдэй хаан сууринд суусны дараа, Монголын эх нутгаас Цагадайн хаант улс, Кипчак хаант улс, Ил хаант улс хүртэлх болон Хархориноос Хятад оронд нэвтрэх өртөөндүүдийг нэмж байгуулаад, өртөөний

«
Төр гүрний засаг зарлиг, цэргийн явдал, гадаад харилцаа зэрэг үйл явдлын хөгжлийг даган, албаны талын мэдээлэл харилцаа одор ирэхүйеэ олиирсон байна. Энэ нь эн тэрүүнд албан бичгийн мэдээллээр илэрч байв.

»

хууль дүрмийг тогтоон нийтэлсэн байна. Хубилай хаан их сууринд суугаад дэлхий дахинд хосгүй өөрчлөлт бүхий өртөө байгуулсан нь хүнд хүчир хаант улсын улс төр, аж ахуйн хөгжилд нөлөөлсөн байна. Он тооллын 1331 онд бичигдсэн "Жин Ши Да Диян" дахь тэмдэглэлийг үндэслэвэл "одоогийн Дунд улсын нутаг дэвсгэр дээр нийт 1500 өртөө байжээ"⁹. Өртөө нь цэрэг-дайны шуурхай мэдээг дамжуулах, эзэн хааны зарлигийг уламжлах ба хааны амралт, элчин сайдын айлчлалд үйлчлэхийн дээр аянчин жинчин амрах, морь унаа солих зэрэгт ашигтай сайн нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байжээ. Өртөөг түүхэн номд зам буюу "замч", өртөөнд тусгай хэл ба бичиг хүргэх хүнийг "улаач" гэдэг байжээ. "Марко Пологийн аяллын тэмдэглэл"-д "хэрвээ ямар нэг газрын тэргүүлэгч урвах буюу

эсвэл өөр хүнд чухал хэрэг тохиолдож, чимээг нь эрхбиш хамгийн түргэнээр уламжлах үед болбоос өртөөний улаач өдөр бүгд 250 газар довтолмой. Тэд нь энэ үед нэгэн цагаан шонхор бүхий пайз авч явна. Түргэн чухал хурдан довтолхын тэмдэг болгомой. Хэрвээ хоёр улаач хамт явах болбоос нэгэн адил сайн морь унаж нэгэн газраас мордон гармуй. Тэд нь биеэ чанга уяад, толгойгоо алчуураар ороож, хамгийн түргэнээр морио ташуурдан явмуй. Энэ мэтээр зогсолгүй довтолж, хорин таван газарт нэг өртөө хүрч сая зогсож, энэ өртөөгөөс бэлтгэсэн хоёр сайн морийг солин унаж, амьсгаа авахгүйгээр урагш явмой. Үүнчлэн нэгэн өртөөгөөс нөгөө өртөө дамжин, морь халан явж, наран шингэхүйд 250 газар явмой¹⁰ гэж улаачийн түргэн шуурхай мэдээ дамжуулах үеийн байдал, тэмдэг, явц хийгээд өртөөний мэдээ зангийн солилцоонд үзүүлж байсан үйл хэргийн тухай тэмдэглэсэн байдаг.

Их Монгол улсын үед бүх улс нэгдэж, шинэ үйлдвэрлэлийн харьцааг байгуулснаас нийгмийн аж ахуй хөгжин цэцэглэж, гадаад дотоодын харилцаа нягтарч, мэдээллийн ажиллагаа ч маш өрнүүн явагдаж байжээ. Үүнд голдуу арилжаа наймаачин, жуулчид, шашин дэлгэрүүлэгч хийгээд элчин харилцаа зэрэг багтана. Марко Поло бол Өрнө дахинд Дундад улсыг таниулснаар барахгүй, бас Дундад улс ба Дундад Азид өрнө дахиныг таниулсан хүн болох юм. "Юань улс дэлхийн 30 гаруй улсуудтай арилжаа худалдааны харилцаатай байжээ"¹¹. "Хубилай хаанаас Ромын пап лам, Францын ван, Английн ван, Испанийн ванд цөм захидал чимээ илгээсэн гэж Марко Поло мэдээлжээ.

Монголын их хаан Хубилай, дөрвөн хаант улсын эзний хувиар тэдгээр ван нарт тамга бичиг илгээж байлаа. 1305 онд Ил хаант улсын хан, Францын ванд илгээсэн захидалдаа Юань улсын тамгыг дарж байв. Юань улсын эхний үед Юань улс болоод Ил хаант улсын хооронд эзэн түшмэлийн харьцаагаар байнгын харилцаатай байжээ"¹².

2 Ардын мэдээлэл. Өргөн уудам тал нутагт аж төрөн амьдарч байсан монголчуудад эрт дээр үеэс "хэл хүргэх" буюу "хэл уламжлах" гэдэг мэдээ занги дамжуулах нэг зүйлийн заншилтай байсан бөгөөд ард нийтээр энэ заншлаа хүндэтгэн үздэг байжээ. Тухайн үед «хэдийвээр "хэл хүргэх" албаны тусгай хүн байсан боловч ерийн үед явуулын хүн, аяны хүнд найдах нь давамгай байжээ. Тиймээс аль нэгэн хүн "хэл"-ийг мартаж, хойшлуулах, санаатай дарж орхих, эсвэл илүү дутуу хэлвэл тэр хүн ард олонд хулгайч, худалчтай адил үзэгддэг"¹³ байв. Энэ нь газар нутаг өргөн уудам, хүн ам сийрэг, зам харилцаа ойр дөт биш, тархай бутархай нүүдлийн аж ахуй эрхэлдэг монголчуудын хувьд айл гэрийн хооронд хэл ус авалцаж, учир явдлаа зөвлөх, албаар дамжуулах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэж байсан нь илэрхий байна.

Монголчууд эрт үеэс учран золгомгоц амар мэндээ асуулцаж, хол ойрын сураг чимээ солилцохыг эрхэмлэдэг бөгөөд үүнийгээ монгол хүний эрхэм нэгэн ёс хэмээн үздэг. Тухайлбал, «Монгол хүн таних танихгүй хамаагүй мэнд сайнаа асуулцан, хөөрөг тамхи зөрүүлмэгц анд найз болсонд тооцдог болохоор доор нь залгаад "Сонин сонсох юу байна?" гэж шууд сураг чимээгээ солилцож гардаг"¹⁴ юм. Мөн

түүнчлэн "Монгол газар нутагт зам зуурт хүн таарад дуугарахгүй өнгөрвөл болохгүй. ...Замд хүн таараад дуугарахгүй өнгөрвөл ёсгүй хэмээмүй"¹⁵. Монголчууд ийнхүү товч дотно мэндчилгээгээр өөр зуураа аж амьдрал, айл саахалт, адуу мал, ус бэлчээр зэрэг олон талын мэдээ зангийг солилцдог.

Үүнээс гадна ан гөрөө хийх, отор нүүдэл, найр наадам, тахилга шүтээн зэрэг зан үйл бол эрт үеэс нааш монгол хүний аж амьдралтай салшгүй нэг хэсэг болсоор ирсэн юм. Ингэж олон хүн нэг доор хуран цуглахдаа харилцан бие биедээ мэдээ занги дамжуулах аз завшаан болдог байсан нь лавтай.

Энд тодруулахад, бидний ярьж буй албаны мэдээлэл болон ардын мэдээлэл нь хоорондоо нэлээд ялгаатай боловч зарим талаар уялдаа холбоотой зүйл байдаг. Албаны мэдээлэл бол ард олонд төр гүрний дүрэм тогтоол, хууль зарлиг зэргийг ухварлан мэдүүлэх зорилготой. Ардын мэдээллийг сайтар ойлгон эзэмших нь албаны мэдээллийг төсөөлөн мэдэхийн үндэслэл болох юм.

Гурав. Мэдээллийн үр нөлөө

Мэдээлэл нь хүн төрөлхтний нийгмийн мэдээ зангийг нэвтрүүлэх ба солилцох хэрэглүүр болсны хувьд олон талын үүрэгтэй юм. XII-XIV зууны үеийн мэдээллийн үйлдэл чадавхийг дараах хэдэн талаар хураангуйлж болно.

1. *Нийгмийн аж ахуй, улс төрийн хөгжлийг ахиулсан.* Монгол хаант улсын үеийн элбэг баялаг мэдээллийн ажиллагаа нь тухайн үеийн нийгмийн аж ахуй болон улс төрийн хөгжлийг ахиулав. Монголчуудын эцгийн эрхт овгийн байгууллын ан агнуур, түүн

цуглуулах аж ахуйгаас Чингис хаан Их Монгол улсыг байгуулж боолт нийгэмд давшин орсон үеийн нүүдлийн мал аж ахуй, арилжаа худалдааны буурай хөгжил, түүнчлэн Юань улс байгуулагдаж Монголын нийгэмд феодалын нийгэм тогтсон бүх явц нь ард иргэдийн үе үеийн хүмүүсийн мэдээлэл харилцаатай салшгүй холбоотой юм. Удаа бүрийн үйлдвэрлэлийн арга мэргэжлийн дэлгэрэлт шинэчлэлт нь цөм нийгмийн аж ахуйн нэн өндөр түвшний хөгжлийн ахиц юм. Улс төрийн талаас үзвэл, балар эртний овгийн байгууллын үйлдвэрлэлийн хэрэгслийг олон нийтээрээ өмчилж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг олон нийтээрээ адил тэгш эдлэх хувийн өмчгүй, дарлал мөлжлөггүй, ардчиллын дүрмийг нэлээд урт хугацаанд хадгалагдаж чадсан нь мэдээллийн арга барилаар нэвтрүүлж ойлгуулсантай холбоотой. Эрх сүр, хууль дүрмийн албадлагагүй, овгийн байгууллын нийгэмд яриа хэлэлцээний мэдээллийн ажиллагаа нь ардчилалд хяналт тавих, нийгмийн эмх журмыг хамгаалахад чухал үүрэг үзүүлж байсан нь гарцаагүй. Түүхийн улиран хувьсахыг даган, ноёрхогч анги нь нэн ухамсартайгаар мэдээ харилцааг дамжиж, дээрээс доош хууль цааз, дүрэм тогтоолоо түгээж, нийгмийн хүрээ ба улс төрийн ноёрхлоо бэхжүүлж байв.

2. *Нийгмийн төрөл бүрийн зөрчлийг зохицуулж, нийгэмших явцыг түргэтгэсэн.* Их Монгол улс байгуулагдах үест мэдээлэл харилцаа нь нийгмийн аль ч этгээдийн зөрчил, хямралыг зохицуулж, тэдгээрийг нэгдмэл цогц болгоход жолоодон дагуулах нөлөө үзүүлсэн байна. Мэдээлэл харилцаа нь аймаг бүлгийн холбоог

бэхжүүлж, нэгдмэл хаант улс болж бүрэлдэх явцыг ахиулж, нэгэн томоохон нийгмийн бүлэглэл цогц болон зохион байгуулалттай хөгжихөд тус нэмэр болов. Мэдээлэлгүй, мэдээллийн нийгмийг зохицуулах зохицуулалтгүй бол Монголын нийгмийн оршин тогтнол хийгээд хөгжил байж чадахгүй юм.

3. Соёлын уламжлал, солилцоог ахиулсан. Нийгмийн соёлыг уламжлах нь мэдээллийн бас нэгэн чухал үүрэг болох юм. Тэр нь голдуу сурган хүмүүжлийн арга замаар биелэгдэж байжээ. Тухайн үед эрдэм мэдлэг сурах нь ноёрхогч ангид хамаарч, зөвхөн Монгол сурвалжитны үр хүүхэд л эрдэм мэдлэг сурах онц эрхтэй байжээ. «Чингис хаан 1204 онд уйгар хүн Тататунгааг Найманы нутгаас олзолж, түүгээр үр хүүхэд ба түшмэл нартаа уйгар үсэг заалгав. Энэ бол Монголын сурган хүмүүжлийн эхлэл боллоо. 1263 онд Хубилай хаан Ёоу Шүгийн сануулгаар сургууль байгуулж, Монгол сурвалжитны үр хүүхдийг сургажээ. 1281 онд Дайду хотод улсын их сургууль байгуулаад сурагч элсэж, эрдэм мэдлэгтэй хятад хүнээр багшлуулж байв. "Засагт туслах нэвтэрхий толь", "Дөрвөн бичиг"-ийг монгол хэлэнд орчуулж, монгол хүүхдийг сургах хичээлийн дэвтэр болгож байв»¹⁶. Юань улсын үед засаг төр болон шашин шүтлэгийн хэрэгцээ шаардлагаас болж орчуулгын ажил ихээр хөгжиж, хятад, төвд, энэтхэг хэлнээс олон ном бичгийг орчуулав. Тухайлбал, 1282 онд "Засагт туслах нэвтэрхий толь"-ийг орчуулж гаргаад дөрвөлжин, уйгаржин хоёр зүйлийн үсгээр барласан байна. 1307 онд орчуулсан "Ачлалт ном"-ыг Дайду хотод модон бараар

барлав. 1305 онд монгол хэлний эрдэмтэн Чойжи-Осор VII зууны үеийн Энэтхэгийн гүн ухааны "Бодичария авадара" хэмээх номыг монгол хэлээр орчуулжээ. Эдгээр нь соёл мэдлэгийн уламжлан хөгжихөд түлхэц хүчин болсноор барахгүй, үндэстнүүдийн соёлын солилцоо, ойлголцоог ахиулсан юм. Бас Чингис хааны Ази, Европыг холбосон том хаант улс байгуулсан явдал нь дорно дахин, өрнө дахины харилцааг шинээр нээж, Хятадын дарь, галт зэвсэг, цаас хийх зэрэг нээлт өрнө дахинд нэвтэрч өрнө дахины шинжлэх ухааны нээлт ч Хятад улс болон дорно дахинд уламжлан иржээ. Өөрөөр хэлбэл, дорно, өрнийн соёлын солилцоо нягтран хөгжсөн байна.

Хураангуйлбал, Монгол үндэстний мэдээлэл харилцаа нь эрт үеэс эхэлсэн боловч тэр нь Хятадын мэдээллийн түүхийн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон байна. Түүхийн сурвалж бичгээс үзвэл, их төлөв аман мэдээллээр нэвтрэлцэн ойлголцож байснаа хэрэгцээгээ үндэслэн туг далбаа, цан хэнгэрэг, пайз тэмдэг, дуун дохио зэргийг хавсарган мэдээ занги уламжлах болж, улмаар үсэг бичгээр мэдээллийн хэрэгсэл болгож, мэдээлэл харилцааны хүрээг өргөтгөн, үр нөлөөг ахиулж, цаг орны хязгаарт чанараас зайлсхийж түүхийн урт удаан цагийн хүрдэнд үйлчилсэн байна.

Ишлэл

¹ Мандах Ү. 1990. Монгол хэлний судлал. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 3 дахь тал.

² 1984. Монголын нууц товчоо // Элдэнтэй, Оюундалайгийн харгуулан хянаж, Хуасай, Дугаржавын буулгав. Өвөр Монго-

лын соёлын хэвлэлийн хороо, 62-63 дахь тал.

³ 1977. Марко Пологийн аяллын тэмдэглэл // Сайшаалын орчуулга. Гириний ардын хэвлэлийн хороо, 27-28 дахь тал.

⁴ 1983. Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичгүүд // Дов цуглуулж эмхэтгэв. Өвөр Монголын хэвлэлийн хороо, 1 дэх тал.

⁵ Мандах Ү. Дурд зох., 3 дахь тал.

⁶ Өлзий. 1988. Монгол хаант улсын засаг дүрмийн тухай // Өвөр Монголын ҮБДС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл. №2, 9 дэх тал.

⁷ Мөн тэнд. №11, 55-56 дахь тал.

⁸ Сэнгэ Ц. 1997. Монголчуудын ертөөний соёл XIII зууны Монголын морин соёлыг холбогдуулан өгүүлэх нь // "Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан". №4, 55 дахь тал.

⁹ 王子今著; "中国古代交通文化",

三环出版社, 1990年, 33 дахь тал.

¹⁰ Марко Пологийн аяллын тэмдэглэл. 336-337 дахь тал.

¹¹ Лиу Жин Сүво. 1985. Монголын хураангуй түүх. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 144 дахь тал.

¹² Лиу Жин Сүво. Дурд. зох., 146 дахь тал.

¹³ Сампилноров. 1990. Монголын зан аалийн тойм // Лионингийн үндэстний хэвлэлийн хороо, 387 дахь тал.

¹⁴ Сампилноров. Дурд. зох., 461 дэх тал.

¹⁵ Лувсанчойдон. 1981. Монголын зан аалийн ойлвор // Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 98 дахь тал.

¹⁶ Лиу Жин Сүво. Дурд. зох., 159 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Лиу Жин Сүво. 1985. Монголын хураангуй түүх. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

2. Лувсанчойдон. 1981. Монголын зан аалийн ойлвор // Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

3. Мандах Ү. 1990. Монгол хэлний судлал. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

4. 1977. Марко Пологийн аяллын тэмдэглэл // Сайшаалын орчуулга. Гириний ардын хэвлэлийн хороо.

5. 1984. Монголын нууц товчоо // Элдэнтэй, Оюундалайгийн харгуулан хянаж, Хуасай, Дугаржавын буулгав. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

6. Өлзий. 1988. Монгол хаант улсын засаг дүрмийн тухай // Өвөр Монголын ҮБДС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл. №2.

7. Сампилноров. 1990. Монголын зан аалийн тойм // Лионингийн үндэстний хэвлэлийн хороо.

8. Сэнгэ Ц. 1997. Монголчуудын ертөөний соёл XIII зууны Монголын морин соёлыг холбогдуулан өгүүлэх нь // "Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан". №4.

9. 1983. Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичгүүд // Дов цуглуулж эмхэтгэв. Өвөр Монголын хэвлэлийн хороо.

10. 王子今著; "中国古代交通文化",

三环出版社, 1990年.

Резюме

Автор статьи на основании анализа первоисточников, исторических документов и исследовательских работ пришёл к выводу, что в XII-XIV вв. информационная коммуникация монголов прошла непростой путь от устной подачи информации к письменному распространению информации. Последний способ распространения информации сыграл большую роль в социально-политическом развитии Монголии и дальнейшей социализации общества.